

## Соёл, урлагийн намтар судлалын онол, үзэл баримтлал

Отгондоогийн Алтанзаяа 

Соёл урлагийн их сургуулийн харьяа Соёл, урлаг судлалын хүрээлэн,  
Улаанбаатар, Монгол Улс  
✉ a.zaya2299@gmail.com

**Хураангуй:** Намтар судлалыг аль ч шинжлэх ухааны салбарт судлан үзэх бүрэн боломжтой. Монголын соёл, урлаг судлалын салбарт түүхэн үүрэг гүйцэтгэсэн бие хүний намтрыг судалснаар тухайн үед тус салбар хэрхэн хөгжиж байсан талаар мөн түүний шалтгаан, хамаарал, ямар үзэл бодол, чиг хандлагатай хүмүүсийн санал, санаачилга хэрхэн нөлөөлсөн зэргийг тодруулах боломжтой. Сүүлийн жилүүдэд намтар судлалын судалгааг олон талаас судлан тодруулах нийгмийн шаардлага үүсэж байгаа тул соёл, урлагийн намтар судлалын хөгжлийг тоймлон үзүүлэхийг зорив. Соёл, урлагийн намтар судлалын онол, үзэл баримтлалыг авч үзсэнээр дараагийн судлаачдад шинжлэх ухааны хийгээд практик ач холбогдолтой юм. Иймийн тул монгол нийгмийн шинжлэх ухааны салбарт намтар судлалын судалгаа хэрхэн хөгжиж буйг тоймлон авч үзлээ. Энэхүү судалгаанд соёл урлагийн салбарын намтар судлалын асуудлын онол, үндэслэлийн асуудлыг авч үзэхдээ түүхэн бие хүний намтрыг герменевтик, түүхэн нөхцөл байдлын баримтын түүвэрлэлт, задлан шинжилгээ, харьцуулалт, нэгтгэн дүгнэх арга зүйг ашигласан болно. Энэ үүднээс соёл урлагийн салбарын нэрт хүмүүсийн намтрыг судлахдаа намтар судлалын шинэ чиг хандлага болох Personal history буюу “хувь хүний түүх”-ийг ашиглаж, аль болох бүрэн бүтнээр нь сэргээхийг чухалчлах, энэ нь хувийн бодигалаг шинжтэй хэдий боловч нөгөөтээгүүр нийгэм, соёл, урлаг, утга зохиолын хөгжлийн өргөн цар хүрээний түүхийг хамарсан онцлогтой болдгоороо шинэлэг, ач холбогдолтой болох юм. Түүнчлэн тухайн хүний амьдрал үйл ажиллагааг түүний аж төрж, бүтээн туурвисан түүхэн цаг үеийн нөхцөл байдал, нийгэм, соёлын гадаад дотоод орчны хүчин зүйлсийн нөлөөтэй уялдуулан авч үзэх нь чухал болно.

**Түлхүүр үгс:** *намтар судлал, хамрах хүрээ, онцлог, чиг хандлага, нөхцөл байдал*

## Theoretical perspectives and conceptual approaches in Biographical studies of culture and arts

Altanzaya Otgondoo 

The Research Institute of Culture and Arts, Mongolian National  
University of Arts and Culture, Ulaanbaatar, Mongolia

✉ a.zaya2299@gmail.com

**Abstract:** Biographical research is a viable and valuable approach across all scientific disciplines. Within the realm of Mongolian cultural and art studies, the examination of individuals who have played a historically significant role offers insight into the development of these fields during particular periods. Such an approach allows scholars to analyze underlying causes, contextual interrelations, and the influence of dominant ideologies, perspectives, and individual initiatives. In recent years, there has been an increasing societal demand for more comprehensive and multidimensional biographical studies. This paper seeks to provide an overview of the development of biographical research in the domains of culture and the arts. By exploring the theoretical underpinnings and conceptual orientations of biographical inquiry, the study aims to offer both scientific and practical contributions for future researchers. Accordingly, the paper outlines the trajectory and current state of biographical research within the scientific landscape of Mongolian society. In this study, the theoretical and methodological foundations of biographical research in the field of culture and the arts are examined. The biography of a historical individual is analyzed using a combination of hermeneutic methods, contextual historical documentation, content sampling, critical analysis, comparison, and synthesis. From this perspective, the study of biographies of prominent figures in the field of culture and the arts emphasizes the use of a new trend in biographical research known as *personal history*. This approach seeks to reconstruct the subject's life as comprehensively and authentically as possible. While it may carry elements of individual subjectivity, it simultaneously encompasses the broader historical context of societal, cultural, artistic, and literary developments, thereby rendering it both innovative and significant in terms of academic and cultural value. It is also essential to examine the life and work of the individual in relation to the historical context in which they lived and created, taking into account the influence of both internal and external socio-cultural and environmental factors that shaped their personal and professional trajectory.

**Keywords:** *biographical study, scope, characteristics, trends, contextual factors*

### Оршил

Намтар судлалын арга зүй нь нийгэм, хүмүүнлэгийн ухаанд түгээмэл хэрэглэгддэг. Нийгэм дэх түүхэн бие хүний эзлэх байр суурь, амьдралын үйл явц нь судлаачдын төдийгүй олон нийтийн анхаарлын төвд байдаг сэдэв. Хувь хүний удам угсаа, төрсөн нутаг, төрсөн болон нас барсан он сар өдөр, гэрлэлт, өссөн орчин, боловсрол, мэргэжил, эрхэлсэн ажил, гаргасан амжилт бүтээл, гавьяа шагнал гэсэн

ерөнхий бүрдлээр намтрыг нь тодорхойлдог жишиг бий. Намтар судлаачдын хувьд тухайн судалж буй хувь хүн нийгэмтэйгээ хэрхэн харилцаж, хариу үйлдэл үзүүлж буйг илүү анхаарч үздэг байна.

Нийгмийн амьдралын субъектив талыг ойлгох, бие хүний хэв шинжийг тодорхойлж, тэдний зүгээс нийгмийн үйл явц болон үзэгдлүүдийг хэрхэн үзэж буйг судлахад намтар судлалын арга чухал байдаг. Намтар судлалд архивын баримт, захидал, хувийн намтар, өдрийн тэмдэглэл, дурсамж зэрэг хэрлэгдэхүүнийг өргөн ашигладаг.

Намтар судлалын аргыг 1920-1930-аад онд АНУ, Герман, Польш улсад боловсруулсан гэж үздэг. 1940-1960-аад онд намтарчилсан түүх нь олж авсан мэдээллийн найдвартай байдлын түвшнийг бууруулдаг гэж шүүмжлэгдэх болсон ч 1970-аад оноос хойш нийгмийн шинэ хөдөлгөөнийг (экологи, залуучууд, эмэгтэйчүүдийн гэх мэт) судлахтай холбогдуулан намтар судлалын аргыг ашиглах нь эрчимжсэн. Намтар судлах аргын хувьд герменевтик (Х.Гадамер), угсаатны зүйн арга зүй (Г.Гарфинкель), өдөр тутмын амьдралын феноменологи, социологи (А.Шюц, Ф.Шюц, П.Бергер, Т.Лакман)-ийн судалгааны оролцоотойгоор өргөжсөн. Намтар судлалын бүтээлүүдэд нийгмийн янз бүрийн бүлгийн нөхцөл байдлын талаар үнэ цэнтэй мэдээлэл агуулагдаж байдаг учраас социологи, нийгэм соёлын антропологи, соёл судлалд өргөн ашигладаг.

Намтар судлалын арга нь нийгмийн янз бүрийн үйл явц, үзэгдлийн микро түвшнийг судлах, нийгмийн оролцогч хувь хүмүүсийн амьдралын стратеги хэрхэн бүрддэгийг ойлгох боломжийг олгодог. Хувь хүний намтар, түүхийг шинжилснээр тухайн нийгмийн хөгжил, нөхцөл байдлын талаарх мэдээллийг тодруулах боломжтой. Жишээ нь, соёл, урлаг судлалын салбарт түүхэн үүрэг гүйцэтгэсэн бие хүний намтрыг судалснаар тухайн үед тус салбар хэрхэн хөгжиж байсан талаар болон түүний шалтгаан, ямар үзэл бодол, чиг хандлагатай хүмүүсийн санал, санаачилга хэрхэн нөлөөлсөн зэргийг тодруулах боломж бүрдэнэ.

Монгол Улсад намтар судлалын төвд хувь хүний онцгой шинжийг нийгмийн хувьсалтай холбон авч үзэхэд ихээхэн анхаарч ирсэн нь намтар судлал хөгжихөд нөлөөлжээ. Намтар нь (*namtar*) цадиг, түүх гэх төвөд үг бөгөөд дээд төрөлхтөн шастир зохиолтой, өөрийн үзэл баримтлалтай нэгний цадиг түүхийг хэлнэ (Бүрнээ, Энхтөр 2013, 288) хэмээжээ. Академич Д.Төмөртоогоогийн “Монгол хэлний үгийн гарлын тайлбар толь”-д “Намтар (*namtar*) ‘сайтар тонилох’ (хутагт хувилгаад орчлонгийн амьдралаас ангижирч нирваанд хүрч, бодь хутгийг олох тухай үгүүлсэн түүх. Хожим аливаа хүний амьдралын замналыг тоочин үгүүлсэн түүхийг нэрлэх болжээ) || хорш: ‘намтар түүх’ || *Kha, Ord, Bur. Namtar, Oir. Namtʰr*” (Төмөртоогоо 2018, 175) гэж тайлбарласан байхаас үзэхэд намтар гэх ойлголт нь эртний төвөд үгээс гаралтай байж болох юм.

Я.Цэвэлийн “Монгол хэлний товч тайлбар толь”-д намтар гэж “1. Аливаа юмны амьдрал ахуйг тоочин бичсэн түүх; түүх намтар, өөрийн намтар гэсэн хоршоо үг үүсгэнэ. 2. Хуучирсан аливаа зохиол тууж; саран хөхөөний намтар; намтраа дуудуулах (муу ажил үйл хийж явсны нь сөхөж тоочих)” (Цэвэл 1966, 368) гэжээ. “Орос монгол толь”-д “намтар гэж биография-намтар, биеийн түүх, цадиг” (Дамдинсүрэн, Лувсандэндэв 1983, 30) хэмээн тус тус тайлбарласан байна.

Эртний уран зохиолд “цадиг” буюу “жэйрав”, түүхчилсэн бичлэгтэйг “вамгиш” буюу “намтар” гэж нэрлэдэг.

Монголын утга зохиолд төвд болон монгол хэлээр бичсэн монгол лам нарын намтар олон бий. Тухайлбал, буриадын бандид хамба Дамбадаржаа Зая (1711-1776)-ын намтрыг буриадын лам Базар Лувсанжамц 1891 онд Лавран хийдэд бичсэн ба Б.Б.Барадиний гар бичмэл эхээс хуулж авч ирсэн 6 хуудас эх Ленинградын Азийн хүрээлэнгийн номын фондод хадгалагдаж буй. Уг бүтээлийг төвөдөөс монгол хэлнээ Дэлгэрийн Галсанжамба (1816 онд төрсөн) 1864-1872 онд 6 тусгай дэвтрээр буриадын Цүүгэл дацанд хэвлэжээ. Харин хүүрнэн өгүүлсэн бичилтээс ялгаатай, үе дамжсан эрдэм номтой, их бичгийн хүмүүсийн намтар, уран бүтээлийн тухай он тооллын эрэмбээр тоочин нэрлэж жагсаасан намтрыг ангилж үзэх шаардлагатай. Мөн намтар түүхийн нэрийн хэлхээст холбогдох зохиолын дотроос ерөнхий намтар, хувийн нууцлаг намтарт холбогдох мэдээллийг ч олж болно. Ерөнхий намтарт энгийн хүмүүсийн намтар түүх, түүнд холбогдох он дарааллын хэлхээс орох агаад бидэнд “намтар” хэмээх ерөнхий ойлголтыг өгдөг. Харин хувийн буюу нууц намтарт голлон нэрт хүмүүсийн буюу Зонховын түүвэр зохиол нэгдүгээр ботид орсон “нууц намтар” зэрэг хүний амьдралтай холбогдсон нууцлаг зүйлийг буюу бусад ойр дотныхныхоо намтартай нэгэн адил бичдэг (“Мань-Гамбум”, “Бадам-Гатан”). Өөрөөр хэлбэл, шашин шүтлэгийн номлол сургаалыг авч хэрэглэсэн, түүнтэй холбогдсон янз бүрийн ер бусын үзэгдлүүд зэрэг “Гэгээнтнүүдийн амьдрал”-ыг магтан дуулсан, домог маягаар хүүрнэн өгүүлсний “Гадаад намтар” буюу “Чий-намтар”, “Хүртсэний тухай ном” буюу “Товъёог”, “Сонссоны тухай ном” буюу “Санъ Иг”, “Дотоод намтар” буюу “Нанги намтар”, “Нууц намтар” буюу “Санви намтар” дотроос энгийн намтарт ордоггүй зохиол бүтээлийн нэрсийг олж харах боломжтой. Хүүрнэн бичсэн хэлбэрээс шалтгаалж аман зохиол, утга зохиол талаас нь ч авч үздэг (Цэзэн 2011, 201).

Хятадад “Намтар судлал”-ыг “传记研究, *zhuanji yanjiu*” гэж нэрлэдэг байна. Энэ нь утга зохиолын нэгэн салбар ухаанд тооцогддог. Гол нь ямар нэгэн хүний түүх, хэрэг учрыг гурван төрлийн арга зүй болох ном судар, аман түүх, судлаачийн өөрийн оролцон ажиглах арга зүйгээр нэгтгэж, бүтээл болгож бичихийг хэлдэг. Түүнчлэн энэ ухаан нь хятад түүх, философийн шинжлэх ухаантай нягт холбоотой хөгжиж ирсэн байна. Философийн хувьд, эртний хятадын философич Күнз, Лаоз гэх зэрэг хүмүүсийн амьдралын түүхийг бичихийн тулд философийн үзэл, намтар судлал хоёр зайлшгүй холбогддог байна. БНХАУ дахь намтар судлал нь хоёр гол хэсгээс бүрддэг. Үүнд, түүхэн баримт дээр суурилсан бодит намтар, уран зохиолын романтик адилгүй ч зохиогчийн өөрийн сэтгэлийн өнгө аясыг оруулсан намтар гэсэн хоёр хэсгээс бүрддэг (Жан чүн рэн 2019, 26).

БНХАУ-ын Бээжингийн Төвийн үндэстний их сургуулийн профессор Хишигтогтох “Монгол намтар зохиолын тойм байдал”, “Монгол намтар зохиолын өвөрмөц онцлог” гэсэн хоёр хэсэгтэй ном бичсэн байна. Нэгдүгээр хэсэг буюу монгол намтар зохиолын агуулгыг дотор нь “Төрийн хаад ноёдын намтар зохиолын тойм байдал”, “Бурханы шашны зүтгэлтнүүдийн намтар зохиолууд” гэсэн хоёр ангилалд хуваан бичжээ. Энэ ангилал нь ерөнхийдөө монгол намтар зохиолын үндсэн агуулгыг тодорхойлсон шинж чанартай (Наранцэцэг 2013, 5).

Үүнд, дорно дахины үндэстнүүдийн утга зохиолын түүхт намтар зохиол чухал байр суурьтай бөгөөд эрт дээд үеийн уламжлалтай байдаг юм. Энэтхэг, төвөдийн эрдэмтэн зохиолчид бурхан шашны зүтгэлтэн, ихэс дээдсийн эрт дээд үеийн намтар түүхийг үлгэр домгийн буюу баттай түүхчилсэн мэдээгээр бичсэн үлгэр домгийн бичлэгтэйг “цадиг” буюу “жэйрав”, түүхчилсэн бичлэгтэйг “вамгиш” буюу “намтар” гэж нэрлэсээр иржээ.

1. Төвөдийн эртний тулгар бичгүүдэд алдарт хаадын тэмдэглэл цөөн бус байдаг. Тэдгээр тэмдэглэлүүдийг утга зохиолын түүхэн намтар зохиолын эртний хэлбэр гэж үздэг юм.
2. VII-IX зууны Төвөдийн Вант төрийг мөхсөнөөс хойш төвөдийн бурхан шашны гэсэн олон салбар бүлэг нь өөрсдийнхөө амжилт бүтээл сайтай, алдар нэр ихтэй, дээд лам нарын үйлс ба эрдмийг ухааруулсан намтар зохиол маш олон зохиосон юм. “Төвөд үндэстний утга зохиолын түүх”-д тэмдэглэсэн ба тэдгээрийн дотроос алдартай зохиолуудыг дурдвал, “Милайрайбын намтар”, “Сажа бандидын намтар” зэрэг одоогоор олдож байгаа 400 гаруй зохиол байна гэжээ. Түүнчлэн, намтар зохиолын дотор ч уг хувь хүний амьдралаас гадна тухайн үеийн нийгмийн үйл явдлын бусад олон талыг тусган харуулсан түүхэн баримт цөөнгүй байдаг. Д.Наранцэцэгийн бичсэн “Монгол намтар зохиолын судалгаа (Цахар гэвш Лувсанцүлтимийн монгол хэлээр туурвисан Богд Зонхавын намтрын жишээн дээр)” нэгэн сэдэвт бүтээлд Богд Зонхавын монгол намтрын судалгаа, ялангуяа уг зохиолыг урлаг, уран зохиолын талаас нь судалж утга зохиолын түүхийн судалгаанд нэгэн шинэ шат нэмжээ (Хишигтогтох 2015, 45) гэж үнэлжээ.

### **Судалгааны арга зүй**

Судалгааны ажлын хүрээнд намтар судлалын гол арга болох задлан шинжилгээ, герменевтик, түүвэрлэх, нэгтгэн дүгнэх, харьцуулалт, түүхэн ба логик арга, баримтын шинжилгээний аргыг ашигласан.

### **Судалгааны үр дүн**

Манай улсад намтар судлалын чиглэлээр судалгаа шинжлэх ухааны салбар бүрд хийгдсээр ирсэн бөгөөд тэдгээрт ихэвчлэн түүхэн хүмүүс, алдар суутны намтар, үйл хэргийг түүхчилсэн байдлаар судалсан байна.

Намтар судлалаар дараах эрдэмтэд нэгэн сэдэвт бүтээл бичиж докторын зэрэг горилжээ. Жишээлбэл, Л.Хасбаатар “Ринчиний Чойномын амьдрал, уран бүтээл” (1997) сэдвээр уран зохиол судлалаар, Ч.Чимэгбаатар “XX зууны монголын хэл шинжлэлийн сэтгэлгээ (Шадавын Лувсанвандан)” (2000) сэдвээр, Ү.Хүрэлбаатар “Д.Намдагийн уран бүтээлийн туурвил зүй: Жүжгийн зохиолын жишээн дээр” (1998) хэл шинжлэлийн ухааны доктор, хэл бичгийн ухааны доктор, Таданори Мацуда “Дашдоржийн Нацагдоржийн амьдрал, уран бүтээл, түүний нийгэм соёлын орчин” (2004) сэдвээр соёл судлалын ухааны докторын зэрэг горилсон. С.Сугар “Сэнгэжавын Гэндэнгийн жүжиглэх, найруулах ур чадварын асуудалд” (2006), Т.Нарантуяа “Уртын дууны урлаг дахь Н.Норовбанзадын өвийн зарим асуудал” (2010), Ж.Эрдэнэхорлоо “Бүжиг дэглээч Цэрэндуламын Сэвжидийн урлах

эрдэм” (2017), Д.Ариунаа “Н.Жанцанноровын хөгжмийн бүтээл дэх үндэсний сэтгэлгээний илэрхийллийн асуудалд” (2021), Г.Жигжидсүрэн “Монголын кино үүсэл хөгжил дэх Дэжидийн Жигжидийн уран бүтээлийн судалгаа” (2021), Дай Цацрал “Намжилын Буяндэлгэрийн дуулах арга барилын уламжлалын асуудалд” (2024) сэдвээр тус тус урлаг судлалын ухааны докторын зэрэг хамгаалсан байдаг. Эдгээр нэгэн сэдэвт судалгааны ажил нь онол, арга зүйн хувьд нийтлэг шинжтэй боловч нэгэн сэдэвт бүтээл болгон авч үзсэнээрээ өөр өөрийн гэсэн онцлогтойгоор монголын соёл, урлагийн салбар чиглэлүүдийн сургалт, уран бүтээл, урын сан болон судалгааны санд хувь нэмэр оруулаад зогсохгүй бүх нийтийн соёлын хийгээд урлагийн боловсрол, хүүхэд залуусын улс үндэстнээрээ, ахмад үеэрээ бахархах үзэл хандлага, хувь хүний намтар, уран бүтээлийн судалгааг хөгжүүлж байгаагаараа үлэмж ач холбогдолтой юм. Харин намтар номзүйгээр Ж.Цэзэн 2011 онд “Монгол судар номын гарчигзүйн бүтэц тогтолцоо (XVII-XIX зуун)” сэдвээр шинжлэх ухааны докторын зэрэг горилсон.

Бичиг үсэг үүсэхээс олон мянган жилийн тэртээгээс тухайн овог аймгийнхаа дотроос шалгарч гарсан баатар эрсийн түүхийг үлгэр домгийн маягаар үе удмаар нь дүрслэн үзүүлсэн зохиол гарах болжээ. Тухайлбал, Монгол ардын баатарлаг туулийн дотор үе удмаар нь түүхчлэн зохиосон шинжтэй орчил туульсын зохиол нь угтаа ямар нэгэн домогт баатар эрсийн түүх намтраас сэдэвлэн гарсан байж болох юм (Наранцэцэг 2013, 6).

Ер нь намтар судлал нь эртний үеэс аман болон бичгийн хэлбэрээр хөгжиж ирсэн байна. Тухайлбал, Рашид Ад-дин Фазлулах “Шашдирын чуулган” хэмээх бүтээлдээ монголчууд овог аймаг бүхэн эртнээс өөрсдийн угсаа гарал, залгамжлагчдынхаа тухай дараа үедээ тасралтгүйгээр ам дамжуулан хэлж өгдөг заншилтай байжээ. Энэ нь эцэг өвгөдийнхөө түүхийг үр удамдаа аман уламжлалаар цээжлүүлдэг ёс заншилтай холбоотой (Рашид Ад-дин Фазлулах 2013, 12) гэж тэмдэглэжээ. Намтар судлалын аман уламжлал одоо ч ямар нэгэн хэмжээгээр хөгжиж байгаа юм.

Шинжлэх ухааны салбар дундын шинж чанартайн улмаас намтар судлал нь орон зайн хувьд их өргөнөөс нарийсах агуулгатай хэдий ч арга зүйн хувьд нарийнаас өргөсөх нийтлэг чанартай гэж үзэх үндэслэлтэй юм. Учир нь намтар судлалд түүх, сэтгэл судлал, философи, антропологи, герменевтик, нийгэм, соёл судлалын шинжлэх ухаанууд уялдаа хамааралтай хөгжсөн байна.

Намтар судлал нь түүх судлалын нэг чухал чиглэлд тооцогддог. 1990 оноос хойш намтар судлал шинэ агуулга, арга зүйгээр хөгжиж, түүх судлалын тэргүүлэх чиглэл болсон бөгөөд энэ шинэчлэлийг түүчээлж яваа түүхчдийн нэг нь академич Ж.Болдбаатар юм. Тэрбээр монголын төрийн зүтгэлтнүүдийн түүхэн хэв шинжийг тодорхойлж намтар судлалын шинэ арга зүйг боловсруулсан. Өөрөөр хэлбэл, түүхийн шинжлэх ухааныг түүхэн хүн судлалын хандлагатай болгож, түүхийн сургалт, судалгаанд түүхэн үйл явцын субьектив, сэтгэл судлалын талыг голлохыг чухалчилдаг арга зүйн шинэ хандлагыг төлөвшүүлсэн (Болдбаатар 2015, 5) гэж үздэг. Тухайлбал, Академич Ж.Болдбаатарын “Монгол түмний сод хүмүүс (Монголын тайз, дэлгэцийн урлагийн зүтгэлтнүүд)” (2017) бүтээлийг урлагийн салбарын намтар судлалын бүтээл гэж үзэх үндэстэй бөгөөд урлагийн хүний



амьдралын туулсан зам, урлагт суралцсан арга барил, урлаг уран сайхны үндсэн ойлголт, намтрын бүтэц, баримтын үнэн байдал, уран сайхны халил зэргийг харьцуулан судалсан бүтээл юм. Улмаар энэ нь нийгэм соёлын үйл явцыг тодруулан дүгнэх бололцоо олгож хувь хүний намтрыг орчин үеийн шинжлэх ухаанд өргөн ашиглах нэгэн сэжүүр болж байна (Болдбаатар 2017, 7).

Түүхийг ард түмэн бүтээдэг хэмээн социалист нийгэмд үзэж байсан боловч хүн төрөлхтний түүхийг бүтээхэд бие хүний гүйцэтгэх үүрэг нийгэмд илүү оролцоотой байсан билээ. Улс төрийн шийдвэр, удирдлага хүнээр дамжин хэрэгждэг учраас энэ харилцаанд “давамгайлагч субъект”-ийг судлан шинжлэх нь түүхийг эзэн биетэй болгож түүхэн үнэнийг тодруулах бололцоо олгодог. Үүнд, намтар судлалын учир холбогдол орших аж. XX зууны монголын түүхэн зүтгэлтнүүдийн намтар судлалын хөгжлийг түүхч З.Лонжид “XX зууны Монголын түүхт хүмүүсийн намтар судлалын тойм” өгүүлэлдээ тодорхойлон авч үзсэн байна. Тэрээр өнгөрсөн зууны монголын түүхэн бие хүний намтар судлалыг цаг хугацаа, агуулгаар нь 1921-1928 он, 1929-1940 он, 1941-1945 он, 1946-1988 он, 1990 оноос хойших үе хэмээн үечилж, үе тус бүрийн онцлогийг тэмдэглэжээ (Лонжид 1999).

Монголын эрт эдүгээгийн зохиолч, уран бүтээлчид өөрийн болон бусдын тухай түүх намтрыг тэмдэглэн бичиж ирсэн уламжлал нь намтар зохиолыг үүсэн бүрэлдэхэд нөлөөлсөн гэж судлаач Д.Цэвээндорж үзжээ. Энэтхэг, төвөдийн цадиг, намтар зохиолын эртний улбаа Монгол оронд намтар зохиол хөгжин боловсроход ихээхэн түлхэц үзүүлсэн (Цэвээндорж 2006, 7). Эрдэмтэн Л.Хүрэлбаатар “Огторгуйн цагаан гарди” (1996) номдоо Огторгуйн цагаан гарди (Өндөр гэгээн Занабазар, 1635-1723), Ухааны таван орны ялгуусан бандид (Зая бандид Лувсанпринлэй, 1642-1715), Сонсголон алдрын цагаан банзад (Хамбо номун хан Агванхайдав, 1779-1838), Эрхэмсэг магтаалын цагаан лянхуа (Эрдэнэ мэргэн бандид Ишсамбуу, 1847-1896), Аварга могойн зулайн чандмань (Догшин ноён хутагт Данзанравжаа, 1803-1856), Улайх униарын өнгө гэрэл (Их сударч, тайж Инжаннаши, 1837-1892), Номт төрийн албан буулга (Лу жанжин гүн, 1854-1909), Найлзуур модны мөчрийн дэргэд (Эрдэнэ мэргэн бандид, ханчин хамбо Жамъянгарав, 1861-1918), Цагийн будангуйд тасхийсэн, төмөр шүглийн дуу (Цанид ловон Шагдар, XIX-XX зууны эхэн), Шимнусын өмгийг очроор дарагч (Жалханз хутагт Дамдинбазар, 1874-1923) нарын намтар бүтээлийг төвөд хэлнээс орчуулан, утга зохиолын задлан шинжилгээ хийсэн байна.

Монголын хөгжим судлалын салбарт Ж.Энэбиш, Д.Батсүрэн, Н.Жанцанноров, Д.Дашдорж, С.Цоодол, Г.Бирваа, Ш.Хэнмэдэх, П.Төмөрбаатар, театр судлалд Э.Оюун, С.Дашдондог, Н.Ганхуяг, С.Сугар, кино судлалд Г.Жигжидсүрэн, цирк судлалд Ё.Батболд, ном зүй судлалд Ж.Цэзэн зэрэг судлаачид намтар судлалын бүтээл хэвлүүлсэн байдаг (Болдбаатар 2017, 7). Мөн дүрслэх урлагийн салбарт эрдэмтэн Л.Батчулууны “Марзан Шарав” (2009), “Зураач С.Нацагдоржийн туурвил зүй” (2008), “Бадамжавын Чогсом” (2013) зэрэг бүтээл олны хүртээл болжээ. Хэл шинжлэлийн салбарт С.Жамбалдорж, Э.Сонинтогос нар “Нэрт монгол хүмүүсийн намтрын ойллого” (2000) хэмээх хамтын бүтээлээ туурвихдаа, намтар судлалын хам болон цуваа цагийн үүднээс задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх арга зүйг гол болгон ашиглажээ. Мөн Ж.Цэцэгмаагийн “Монгол оронд Жамсрангийн Цэвээний

өрнүүлсэн эрдэм шинжилгээ, соён гэгээрүүлэлт, нийгэм улс төрийн үйл ажиллагаа (1911-1931)” (2008), “Жамсрангийн Цэвээний замын тэмдэглэлүүд 1903-1910 он” (2014) зэрэг ном нийтийн хүртээл болсон байдаг.

Эрдэмтэн Ж.Болдбаатар “Монголын түүхэн хүн судлал: Эрдэм шинжилгээний өгүүллийн чуулган” бүтээлдээ түүхэн хүн судлал буюу намтар судлалын судалгааны арга зүйн асуудлыг дараах байдлаар авч үзэж болно хэмээжээ. Тухайн үеийн улс төрийн зүтгэлтний түүхэн хэв шинжийг шалгуур тогтоон нарийвчлан тодорхойлох нь түүхийг түүхэн хүн судлалын үүднээс авч үзэж, түүхийг эзэнгүйдүүлэх явдлаас ангижрах чухал ач холбогдолтой юм. Түүхэнд тухайн төрийн зүтгэлтний гүйцэтгэсэн үүрэг роль, байр суурийг үнэлэхдээ дараах шалгуурыг баримталж болох юм. Энэ нь:

- Удам гарваль, улс төрийн намтар,
- Үйл ажиллагаа явуулж байсан нийгмийн орчин, дотоод, гадаад түүхэн тодорхой нөхцөл,
- Зорин тэмцэж буй үйл хэргээ анх санаачилж, түүнийгээ хэрхэн гартаа авсан болон зоримог байдал,
- Тэмцлийн арга, хэрэгслийн сонголт, шинж төлөв,
- Нийгмийн анги, бүлгийн эрх ашгийг илэрхийлэх хандлага,
- Улс төрийн шадарлал,
- Хувь хүний зан чанар, ноён нуруу гэсэн шалгуурыг авч үзсэн (Болдбаатар 2018, 5).

Мөн тэрбээр төрийн зүтгэлтнийг үнэлэхдээ, тухайн үеийн нийгмийн оюунлагийн /ментальность/ түвшинд авч үзэх ёстой. Өөрөөр хэлбэл, XIII зууны улс төрийн зүтгэлтнийг 1911 оны юм уу, эсвэл эдүгээ үеийн төрийн зүтгэлтэнтэй адилтган үзэж, эдүгээчилсэн шаардлага тавьж болохгүй юм. Төрийн зүтгэлтнийг түүхэн үзлийн бус, түүхэн ухаарал сургамжийн үүднээс үнэлэх нь зүйд нийцнэ. Дээрх арга зүйн зарчмыг удирдлага болгон XX зууны монголын төрийн зүтгэлтний түүхэн хэв шинжийг судлан тодорхойлох нь түүх, онол-үйлдлэгийн чухал ач холбогдолтой гэжээ (Болдбаатар 2018, 5).

“Түүх зулсан он жилүүдийн ойллого-II” (2003) эрдэм шинжилгээ, сурталчилгааны өгүүллийн эмхэтгэлийн “Түүхэн хүн судлал, намтар судлалын асуудлууд” хэмээх гутгаар хэсэгт монгол төрийн зүтгэлтний түүхэн хэв шинж, улс төр, төр болон шинжлэх ухаан, шашин, соёлын зарим зүтгэлтнүүдийн намтрын балархайг тодруулахыг зорьжээ. Тухайлбал, “XX зууны монголын төрийн зүтгэлтний түүхэн хэв шинжийг тодорхойлох тухай асуудалд” өгүүлэлд монгол төрийн зүтгэлтний түүхэн хэв шинж төлөвшсөн үйл явцыг судалж үзэхэд, дараах байдлаар ангилж болохоор байна гэжээ. Үүнд:

1. Хаан төрийн сурвалжит түшмэл маягийн хэв шинж
2. Шилжилтийн маягийн заримдаг хэв шинж (1921-1952)
3. Захиран тушаах хүнд сурталт маягийн хэв шинж (1952-1990)
4. Ардчилсан хэв шинж (1990-ээд он) хэмээн ангилан үзсэн (Болдбаатар 2003, 152).



“Тод номын гэрэл төв”-өөс эрхлэн хэвлүүлдэг 4 цувралын нэг нь “Bibliotheca oiratica-Biography seria” цуврал юм. “Biography seria” цувралаар түүхт хүмүүсийн намтар, тэдний үйл ажиллагааг нэхэн судалсан бүтээл, дурдатгал дурсамж, аман түүхийн бүтээлийг хэвлүүлж иржээ. Нийт 23 цуврал эрхлэн гаргасан ба 2024 онд Идамцоогийн Даваагийн “Мэдлэг хөөсөн зам (Эрдэмтний дурсамж тэмдэглэл)” (Сүхбаатар 2024) номыг хэвлүүлжээ.

Монгол Улсын ШУА-ийн Философи, социологи, эрх зүйн хүрээлэнгээс эрхлэн гаргасан “Философи, эрх зүйн судлал” (2012) сэтгүүлд Ч.Жүгдэр, Д.Дашжамц, С.Норовсамбуу, Г.Лувсанцэрэн, Х.Нямбуу, Т.Содномдаргиа нарын эрдэмтдийн намтар түүхийг тэдний эрдэм судлалын ажилтай холбон бичсэн байгаа нь бидний сонгосон сэдэвтэй холбоотой буюу эрдэмтэн хүний эрдмийн ажлыг түүний намтартай хэрхэн холбож, найруулан бичих талаар жишээ болохуйц судалгааны бүтээлүүд болжээ. Эрдэмтэн Г.Лувсанцэрэн, А.Жамбал нар “Гүн ухаантан Чимидийн Жүгдэр (Амьдрал үйлс, бүтээл туурвил)” (2011) номдоо Академич Ч.Жүгдэрийн амьдрал, намтрын тойм, Философийн эрдэм мэдлэг түгээх, багшлах, судлан шинжлэхүйн үйлсэд, Монголын гүн ухаан, нийгэм-улс төрийн сэтгэлгээний түүхэн үйл явцыг шинжлэн боловсруулсан нь, Академийн хүрээлэнг үүсгэлцэн удирдаж, буддистуудын энх тайвны үйл хэрэгт зүтгэсэн нь гэсэн агуулгын хүрээнд түүний ажил амьдралын түүхэн замналыг бичжээ.

Монголын соёл, урлаг судлалд намтар судлалын ажлууд цөөнгүй бий ч энэ чиглэлийн онол, арга зүйн асуудлыг эргэн харах шаардлагатай байгаа нь судалгааны ажлуудаас харагдаж байна. Нэн ялангуяа тухайн хүнийхээ хийж бүтээсэн үйл хэргийн далайц, ажиллаж амьдарч байсан түүхэн цаг үеийн онцлог, хувийн зохион байгуулалт, хийж бүтээх хүсэл эрмэлзэл гэх мэт олон хүчин зүйлийг харгалзсан системт хандлага, түүнийг илэрхийлэн судлан гаргах оновчтой онол, арга зүй, аргачлалын талаар бид нухацтай бодолцох шаардлагатай байна. Тухайлбал, СУИС, СУСХ-ээс эрхлэн гаргаж буй “Соёл урлагийн тайлбар толь”-ийн “Дүрслэх урлаг”, “Шашин соёл”, “Музей”, “Бүжиг”, “Хөгжим”, “Соёлын өв”, “Номын сан”, “Телевиз” толиудад хүмүүсийн намтар түүхийг авч үзэхдээ цол хэргэм, эрдмийн зэрэг цол, шагнал гавьяа, монголын соёл урлагийн салбарт оруулсан хувь нэмэр зэргийг харгалзан үзэж тухайн цуврал толийг бичих арга зүйн дагуу бичиж оруулсан байна. Эдгээр бүтээл нь монголын соёл урлаг судлал дахь намтар судлалын хөгжлийг харуулах гол үзүүлэлт болж байгаагаараа онцлог юм. “Мөнхийн найруулагч Бирваагийн Мөнхдорж” (Цэнд-Аюуш 2019) бүтээл Б.Мөнхдорж найруулагчийн театрын найруулагч, багш, найруулагч, жүжигчдийг бэлтгэх сургалтад өөрийн арга зүйг бий болгосон сурган хүмүүжүүлэгч гэдгийг судлан бичсэн намтар судлалын бүтээл юм.

СУИС-аас 2016 оноос эхлэн эрхлэн гаргаж байгаа “Профессорын цуврал”-аар монголын соёл, урлагийн салбарын амьд домог болсон, нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн алдартан, сурган хүмүүжүүлэгч багш нарын амьдрал, уран бүтээлийн, ажлын туршлагыг залуу үеийнхэндээ өв болгон бичиж үлдээх ажлыг залуу судлаач багш нартай хамтран хийж байна. “Уртын дууны хатан хаан” (2016) бүтээл алдарт уртын дуучин Н.Норовбанзадын тухайд, “Монгол дуурийн ханхүү” (2017) бүтээл алдарт дуучин Г.Хайдавын ажил хөдөлмөр, уран бүтээлийн түүхэн

замналын тухайд, “Амбасэлмаа” (2018) нэрт сэтгүүлч Амбасэлмаагийн ажил амьдралын түүхэн замналын тухай, “Нацагийн Жанцанноров” (2022) Төрийн соёрхолт хөгжмийн зохиолч Н.Жанцанноровын амьдрал, ажил үйлсийн түүхэн замналыг, “Намсрайн Сувд” (2022) Монгол Улсын Хөдөлмөрийн баатар Н.Сувдын ажил, амьдралын түүхэн замналыг, “Сономын Лувсанвандан” (2023) СУИС-ийн Соёл, урлаг судлалын хүрээлэнг үүсгэн байгуулагч, эрдэмтэн С.Лувсанванданы ажил амьдралын түүхэн замналыг, “Дэмидийн Хишигт” (2022) кино урлагт өөрийн амьдралаа зориулсан найруулагч, багш Д.Хишигтийн ажил, амьдрал, уран бүтээлийн тухай өгүүлэх цувралыг тус тус эрхлэн гаргасан байна.

Намтар судлалтай холбогдол бүхий судалгааны бүтээл нийгмийн шинжлэх ухааны салбарт сүүлийн үед түүхчилсэн байдлаар судлагдах нь элбэг болсон. Намтар нь он дараалсан түүх бичлэг (летопись) бус бөгөөд тухайн нийгмийг тэр хэвээр нь нүдэнд зураглан буулгадгаараа уран зохиолын төрөл зүйлд багтана. Намтар зохиох, зохиолчийн намтрыг уран бүтээлтэй нь холбон судлах нь нийгэм цаг үетэйгээ холбогдож ирсэн бөгөөд судалгааны үнэлэмжийн хувьд сонирхолтой байр суурийг шаарддаг (Цэвээндорж 2006, 12).

Б.Содном “Д.Нацагдоржийн намтар зохиол” (1966), Д.Цэдэв “Их Нацагдоржийн хэлхээгүй сувдын учиг” (2016), Монгол Улсын шинжлэх ухааны 108 ботийн II ботид Э.Пүрэвжав “Онходын Жамъян” (2003), III ботид Н.Хишигт “Базарын Ширэндэв” (2003), IV ботид Ц.Шагдарсүрэн, О.Адьяа “Бямбын Ринчен” (2003), VI ботид Д.Төмөртоогоо, Э.Пүрэвжав, Л.Маналжав “Шадавын Лувсанвандан” (2005), А.Жамбал “Чадраабалын Лодойдамба Соён гэгээрүүлэлтийн нэрт зүтгэлтэн” (2017) зэрэг эрдэмтдийн намтар бүтээл хэвлэгджээ. С.Гомбожавын “Монголчуудын төвд хэлээр зохиосон зохиолын зүйл”, Ч. Алтангэрэл “Монгол зохиолчдын төвөдөөр бичсэн зүйл” I дэвтэр (1967, 1968), Р.Бямбаагийн “Монголчуудын төвд хэлээр туурвисан, монгол хэлэнд орчуулсан номзүйн бүртгэл” I дэвтэрт Анхдугаар Жавзандамба хутагт Лувсандамбийжалцанаас 9-р Богд Жамбалнамдолчойжижалцан (1932-2012) хүртэлх 9 үеийн их Богдуудын намтар түүх, тэдний зохиож бүтээсэн ном зохиол орсон (Бямбаа 2004, 298).

Төр, шашны том зүтгэлтэн нарын тухай бие даасан тусгай төрөл зүйл төлөвшин хөгжихөд энэтхэг, төвөдийн намтар зохиолын дурсгалууд нөлөөлөх болжээ. Өөрөөр хэлбэл, XIV зууны эхэн үеэс монголын уран зохиолын түүхэнд төлөвшин хөгжсөн намтар зохиол нь эртний гэрийн үеийн бичиг, аман уламжлалын үлгэр домог, хожуу үеийн орчуулгын зохиолын харилцан нөлөөллийг авч биеэ даасан төрөл зүйлийн түвшинд хөгжиж иржээ (Наранцэцэг 2013, 6) хэмээн судлаач Д.Наранцэцэг шашны зүтгэлтний намтрын судалгааны ажилдаа өгүүлсэн.

1999 оноос эхлэн Э.Пүрэвжав тэргүүтэй эрдэмтэд “Монгол хэл бичгийн судлал”-ыг ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгээс төрөн гарсан хэл шинжлэл, утга зохиолын салбарын эрдэмтдийн намтар, бүтээлийн жагсаалт, бүтээлээс нь нэг гол өгүүллийг төлөөлүүлэн хэвлүүлж уламжлал болоод байна. Мөн “XX зууны монгол зохиолчид” цувралаар монголын нэрт эрдэмтэн зохиолчдын намтар, уран бүтээлийн товчооныг мөн гаргадаг. Одоогоор 99 цувралыг эрхлэн гаргажээ.

Намтар судлал гэдэг нь хүн, түүний мөн чанарын судалгаа юм. Хүн, түүний мөн чанар, түүний оршихуй, хүний ирээдүйн асуудал нь хүн төрөлхтний олон

мянган жилийн түүхийн туршид тулгарч байсан асуудлын дотроос хамгийн үндсэн асуудал байсаар ирсэн түүхтэй. Иймд хүний тухай асуудлыг судалдаг философийн хүн судлал бол философийн мэдлэгийн онцгой хүрээ (Дарьхүү 2022, 154). Манай улсад хүний тухай асуудлаарх шинжлэх ухааны судалгаа, сургалт болон хүн төвт хөгжлийн талаарх төрийн бодлого нь философийн хүн судлалын онол-арга зүйг дутуу үнэлэх, түүнээс хол хөндий алсарч байгааг анхаарч, энэ алдаагаа цаг алдахгүй нэн даруй засаж залруулах нь монгол хүний хөгжил болон нийгмийн хөгжилд олон талын ач холбогдолтой (Дарьхүү 2022, 154).

Хүний тухай асуудал нь философийн судалгаанд мөнхийн, эн тэргүүний асуудлын нэг болсоор ирсэн юм. Хүнээ дээдлэх, нийгмээ улам энэрэнгүй, хүмүүнлэг болгон хөгжүүлэх, улсынхаа дэвшил хөгжлийг шинэ дээд түвшинд гаргах эрхэм чухал зорилт тавьж байгаа нөхцөлд хүнээ судалж, онцлог болон нийтлэг шинжүүдийг нь тодруулж, хүний хүчин зүйлийг өргөн ашиглах явдал нэн тэргүүний ач холбогдолтой (Балхаажав 1992, 3). Энэ үүднээс XX зуунд монголын шинэ бие хүний судалгаа аажмаар үүсэн төлөвшиж, өнөөгийн түвшинд хүрсэн түүхтэй бөгөөд бие хүний судалгааны түүхийг судлах нэн шаардлагатай болж хэмээн үзэж, 1950-1960 оны үеэс хүний асуудал, нийгмийн ухамсар, ертөнцийг үзэх үзэл, шашны үзэл, зан суртахууны тухай Марксист-Ленинист онолын үндэслэлийг тайлбарлаж, сурталчилсан ном товхимлууд гарах болсноор бие хүний судалгааны эх тавигдсан гэж үздэг (Дашжамц 1989, 4).

“БНМАУ дахь социалист бие хүний төлөвшил хөгжлийн асуудал” хэмээх номд бие хүний судалгааны онол, арга зүйн асуудал буюу хүний тухай Марксист-Ленинист онолын хөгжил, БНМАУ-ын Шинэ бие хүн төлөвшсөн нь, түүний үндсэн шатууд, Социалист байгуулалт ба өнөөгийн шинэ бие хүний хөгжил, Бие хүний үзэл санаа-улс төрийн хүмүүжил, эдийн засгийн хүмүүжил, эх оронч интернационалч үзэл, Социалист ёс суртахууны төлөвшил, бие хүний гоо сайхны төлөвшил, БНМАУ дахь шинэ хүний талаарх хөрөнгөтний үзэл санааг шүүмжлэх талаар өгүүлж тухайн нийгмийн шинэ хүнийг бие хүний төлөвшил талаас нь авч үзжээ (Дашжамц 1989, 17).

Хүн судлаач Ц.Балхаажав “XX зуун ба хүн” сэдвээр шинжлэх ухааны доктор (Sc.D)-ын зэрэг хүртсэн. “Хүний хөгжлийн онол арга зүйн философи үндэслэл” (1992) бүтээлдээ хүнийг үзэх үзлийн төв цэг, XX зууны хүн түүний үйлдэл, монгол хүний сэтгэл зүйн уламжлалт шинж, хүний хүн орчин, хүнийг хөгжүүлэх үндэс суурь, зангилаа асуудал, хүүхдийг багаас нь зөв хүмүүжүүлэх, хүүхэдтэй ажиллах арга ухаан, ахмад үеэс авч үлдэх өв сан зэргийг нарийвчлан судалж хэд хэдэн санал дэвшүүлжээ. “Үүрдийн дурсгал номын хөшөө” (2004) цувралын II ботид хүний хөгжлийн онол, арга зүйн философи үндэслэлийг бүхэлд нь зарим нэг өгүүллийн хамт гаргасан. “Хүн та хэн бэ” (2006) эмхэтгэлд хүнийг хэрхэн ойлговол зохихын тоймыг үзэл бодлын хялбаршуулсан арга хэлбэрээр өгүүлсэн. “Үзэг, цаас бид гурав” (2007) нэртэй гар бичвэрийн түүвэр эмхтгэлд хүний талаар юу ажиж, юу ухаарч, юу мэдсэнээ өдөр тутмын тэмдэглэл маягаар илэрхийлсэн. “Хүн хэмээх агуу их ертөнц” (2012), “Хөгжил” (2013) зэрэг номд хүний үүсэл хөгжлийн асуудлын хүрээнд өөрийн судалгааны гол гол үр дүнг нэгтгэн өгүүлжээ.

Б.Батчулуун “Философи дахь хүний асуудал” (2001) бүтээлдээ хүнийг танин мэдэхэд урлаг утга зохиол, шашин, шинжлэх ухаан, философи ямар өвөрмөц талтай байдаг, хүний гарал үүслийн талаар үлгэр домгоос эхлэн шинжлэх ухаан юу өгүүлдэг, ямар дүгнэлтэд хүрснийг, хүний ахуйн төгсгөл буюу үхлийн тухай шашин, шинжлэх ухаан, философи юу гэж үздэгийг өгүүлсэн.

Б.Галиндэв “Хүний төрх” (2015), “Хүн байх ухаан” (2016) бүтээлд үе, үеийн нийгмийн ёс зүйн хэм, хэмжээ хэрхэн өөрчлөгдөж байгааг дурдаад нийгэмд ёс зүй нь улсын хөгжлийн түлхүүр юм, эх оронч үзэлтэй байх, эх оронч үзлийн үлгэр дуурайлын тухайд өгүүлээд ёс суртахуунтай монгол хүний төлөвшилд нийгэм, улс төр, бизнес, уран зохиол, шинжлэх ухаан, шашин хэрхэн нөлөөлдөг, холбоо хамааралтай болох талаарх асуудлыг хөндөн тайлбарлажээ.

Хятадын уламжлалт философийн хүний талаарх үзэл баримтлалд “байгалийн хүн”, “нийгмийн хүн” аль алиныг авч үздэг. Хүний уг чанарын асуудал, хүний гадаад ертөнцийн харилцан холбоо зохицлыг бий болгох буюу оршихуйн тухай асуудлыг авч үзсэн (Бурова 1990, 135).

“Философийн үндсэн асуудал бол хүний тухай асуудал мөн” хэмээн Мартин Хайдеггер онцгойлон тэмдэглэж, энэ асуудалд өөрийн онолын судалгааг чиглүүлсэн байдаг. Орчин үеийн философичид хүний ухамсарт чанар нь амьдралыг хүн өөрөө бүтээх, нийгэм түүхийн, байгалийн, сэтгэл зүйн болон бусад орчныг өөрөө ухамсартай сонгох, эс сонгох бололцоог олгож байгааг өнөө үед илүүтэй онцлон үзэх болж байна. Хүний ухамсарт сонголт нь тухайн түүхэн тодорхой орчинд бүтээн туурвих эрх чөлөөг өгч байдаг. Иймд бидний судалгаанд түүхэн тодорхой үед амьдарч, өргөн далайцтай үйл ажиллагаа явуулж байсан хувь хүний өөрийн сонгосон сонголт, нийгэм болон шинжлэх ухаанд эзэлсэн байр суурийг ухамсрын бүтээлч байр сууринаас үзэхийг эрмэлзсэн билээ.

### Хэлэлцүүлэг

Соёл урлагийн намтар судлалын онол, үзэл баримтлалын талаарх энэхүү судалгаа нь Монгол Улсад, тэр дундаа соёл, урлагийн салбарын хөгжлийн судалгааны цар хүрээ, хамрах байдал, нийгмийн нөхцөл байдлыг тодруулах ач холбогдолтой юм.

Монголын нийгмийг соён гэгээрүүлэх, соёл, урлагийн талаарх бодлого тодорхойлох, тус салбарыг хөгжүүлэхэд өөрийн ухамсарт амьдралыг зориулсан соёл, урлагийн салбарын зүтгэлтнүүдийн намтар судлалыг хөгжүүлэх шаардлагатай байна.

### Дүгнэлт

Монгол Улсад намтар судлал нь эртний түүхэн тэмдэглэлээс эхлэлтэй бөгөөд өнөө үед түүх, урлаг, соёл, аман түүх, нийгмийн чиглэлд өргөжин хөгжиж байна. Монголын соёл, урлагийн намтар судлал нь түүхэн хөгжлийн онол, соёлын антропологи, намтар судлалын уламжлалт арга зүйг хослуулсан, хувь хүний замналыг соёлын өргөн хүрээнд судлах үзэл баримтлалтай салбар юм. Энэхүү судалгааны арга зүй, онолын суурь нь монголын соёлын өвийг судлах, хадгалах, түгээн дэлгэрүүлэхэд чухал хувь нэмэр оруулах болно. Нийгэм соёлын зүтгэлтэн,

түүхэн бие хүмүүсийн намтрын судалгаа (намтар судлал-biographica-биографика) бол түүх, нийгмийн ухааны харьцангуй бие даасан нэгэн чухал хэсэг бөгөөд судалгааны зохих арга зүй, хандлага, архивын болон үнэн бодитой бусад баримт, мэдээ материалыг ашиглаж судлах, тайлбарлах, бүхэлдээ авч үзэн буй асуудалд түүхэн тодорхой нөхцөл байдлын үүднээс хандахыг шаарддаг судлагдахуун болох нь судалгаанаас харагдаж байна.

Намтар судлал нь эртний үеэс аман болон бичгийн хэлбэрээр хөгжиж ирсэн түүхэн уламжлалтай. Намтар судлалын ухаан нь түүх, шашин, урлаг, эртний уран зохиол, нэрт хүмүүсийн намтар судлал гэсэн чиглэлээр үүсэж хөгжсөн байна. Намтар судлалд түүх, сэтгэл судлал, философи, антропологи, герменевтик, нийгэм, соёл судлалын шинжлэх ухаанууд харилцан уялдаа хамааралтай хөгжсөн байна. Соёл, урлагийн салбарын нэрт хүмүүсийн намтрыг судлахдаа намтар судлалын шинэ чиг хандлага болох Personal history буюу “хувь хүний түүх”-ийг ашиглаж, аль болох бүрэн бүтнээр нь сэргээхийг чухалчлах, энэ нь хувийн бодигалаг шинжтэй хэдий боловч, нөгөөтээгүүр нийгэм, соёл, урлаг, утга зохиолын хөгжлийн өргөн цар хүрээний түүхийг хамарсан онцлогтой болдгоороо шинэлэг, ач холбогдолтой. Тиймээс тухайн хүний амьдрал үйл ажиллагааг түүний аж төрж, бүтээн туурвисан түүхэн цаг үе, тэр үеийн нийгэм, соёл, урлаг, боловсрол, улс төр, гадаад дотоод орчны бүрэлдэн тогтсон нөхцөл байдалтай уялдуулан авч үзэх нь чухал болно.

#### Ашигласан материалын жагсаалт

- Балхаажав, Ц. 2012. *Хүн хэмээх агуу их ертөнц*. Улаанбаатар: Интерпресс ХХК.
- Болдбаатар, Жигжид. 2017. *Монгол түмний сод хүмүүс (Монголын тайз, дэлгэцийн урлагийн зүтгэлтнүүд) VII боть*. Ред. Батсайхан Д. Улаанбаатар: Соёмбо принтинг ХХК.
- Болдбаатар, Жигжид. 2015. *Монгол түмний сод хүмүүс (Монгол төрийн зүтгэлтнүүд) Дэд боть*. Ред. Мягмарсамбуу Г. Улаанбаатар: Соёмбо принтинг ХХК.
- Болдбаатар, Жигжид. 2018. *Монголын түүхэн судлал. Эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэл, нийтлэл Боть III*. Улаанбаатар: Соёмбо принтинг ХХК.
- Бурова, В.Г. 1990. *Древне Китайская философия*. Москва.
- Бүрнээ, Д., Энхтөр, Д. 2013. *Төвд-Монгол толь*. Хян. Чоймаа Ш. (нэмэн засварласан 5 дахь хэвлэл). Улаанбаатар.
- Бямбаа, Р. 2004. *Монголчуудын төвд хэлээр туурвисан, монгол хэлэнд орчуулсан номзүйн бүртгэл Боть I*. Улаанбаатар.
- Дамдинсүрэн, Ц., Лувсандэндэв, Д. 1983. *Орос монгол толь*. Улаанбаатар: УХГ.
- Дарьхүү, Р. 2022. “Философийн хүн судлалын арга зүйн асуудалд.” *Философи ба шинжлэх ухааны танин мэдэхүй: онол арга зүйн асуудлууд*. Эмхэт. Мягмарсайхан П. Улаанбаатар.

- Дашжамц, Д. 1989. *БНМАУ дахь социалист бие хүний төлөвшил хөгжлийн асуудал*. Улаанбаатар.
- Жан Чүн Рэн. 2019. *Намтрын судалгааны арга зүй*. Бээжин: Бээжингийн багшийн их сургуулийн хөгжмийн сургууль.
- Лонжид, З. 1999. *XX зууны монголын түүхт хүмүүсийн намтар судлалын тойм. XX зууны Монголын түүхийн асуудалд (Эрдэм шинжилгээний хурлын өгүүллүүдийн эмхэтгэл)*. Улаанбаатар.
- Наранцэцэг, Д. 2013. *Монгол намтар зохиолын судалгаа (Цахар гэвш Лувсанцүлтимийн монгол хэлээр туурвисан Богд Зонхавын намтрын жишээн дээр)*. Улаанбаатар.
- Рашид Ад-дин Фазлулах. 2013. *Шашдирын чуулган*. Улаанбаатар.
- Төмөртоогоо, Д. 2018. *Монгол хэлний үгийн гарлын тайлбар толь*. Улаанбаатар.
- Хишигтогтох, Ч. 2008. *Эртний уран зохиолын шинэ судлал*. Хөрв. Сүглэгмаа Х. Улаанбаатар.
- Хүрэлбаатар, Л. 1996. *Огторгуйн цагаан гарди*. Улаанбаатар: Адмон ХХК.
- Цэвэл, Я. 1966. *Монгол хэлний товч тайлбар толь*. Ред. Лувсанбалдан Х. Улаанбаатар: ШУА-ийн хэвлэх үйлдвэр.
- Цэвээндорж, Д. 2006. *Монгол зохиолчийн намтар зохиолын судалгаа*. Улаанбаатар: Соёмбо принтинг ХХК.
- Цэзэн, Ж. 2011. “Монгол судар номын “гарчигзүйн” бүтэц тогтолцоо (XVII-XIX зуун).” Sc.D дисс., Монгол Улсын Шинжлэх ухааны академи, Монгол Улсын Соёл урлагийн их сургууль.
- Цэцэгмаа, Ж. 2008. *Монгол оронд Жамсрангийн Цэвээний өрнүүлсэн эрдэм шинжилгээ, соён гэгээрүүлэлт, нийгэм улс төрийн үйл ажиллагаа (1911-1931)*. Улаанбаатар.